

“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

№ 01.

Улаанбаатар хот

“Сэндли ББСБ” Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал Улаанбаатар хот, Bluesky tower-ын 2 давхарт, emerald танхимд 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 14 цагт эхлэв. Хурлыг “Си Эм Си Консалтинг” ХХК-ийн MI Survey програмыг ашиглан ирц бүртгэл болон санал хураалтыг зохион байгуулж, zoom онлайн платформыг ашиглан цахимаар шууд дамжуулан, танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдав.

Хэлэлцэх асуудал:

1. Дүрэм батлах тухай
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Б.Одгэрэл: Хурлын дэгийг танилцуулав.

Хурлын ирц

Тооллогын комиссын дарга Д.Баярбатын танилцуулснаар:

Тооллогын комиссын ирцийн дүнг танилцуулья. Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь: “Сэндли ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн нийт 223,570,000 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 223,248,053 ширхэг хувьцаа, саналын эрхгүй 31,947 ширхэг хувьцаа байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 86,33 % болж Хувьцаа эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай

Б.Наранбат: /Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж үг хэлэв/

Хөрөнгийн биржийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/85 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 413 дугаартай тогтоолоор тус тус нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дагуу 2022 оны 09 дугаар сарын 26-ны анхдагч зах зээлийн арилжаанд амжилттай оролцсон. Үүний хүрээнд 3416-н хувьцаа эзэмшигчээс 10,050,000,000 /Арван тэрбум тавин сая / төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Хурлын даргаар миний бие ТУЗ-ийн дарга Б.Наранбат, хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Гантуяа, А.Итгэлт нар ажиллаж байна. Мөн тооллогын комиссын даргаар Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал Д.Баярбат, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Гантуяа, Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн Т.Бадмаанямбуу нар ажиллаж байна.

Ийнхүү хурал нээснийг мэдэгдье.

Л.Нарантуяа: /Хурлын дэгийг танилцуулав/

Г.Гантуяа: Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураалт эхэлсэн байгаа. Санал хураалт явагдаж байх үед санал хэрхэн өгөх талаар зааврыг танилцуулья.

Б.Наранбат: Өнөөдрийн хурлаар хэлэлцүүлэх, та бүгдийн саналаа өгөх Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид танилцуулах болно. /ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулав/

Б.Мөнхцэцэг: /Шинэчлэгдсэн дүрмийн төслийг танилцуулав./

Б.Наранбат: Та бүхэнд асууж, тодруулах, саналаа хэлэл зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч Залаа-Уул: Дүрмийн төсөлд нэрлэсэн үнэ 50 төгрөг гэж оруулсан байна. Анх анхдагч арилжаанд 150 төгрөг гэсэн үнэтэйгээр зарсан. Яагаад одоо дүрмэндээ нэрлэсэн үнэ нь 50 төгрөг байгаа юм бэ?, Анх санал болгосон 150 төгрөгийн үнээрээ дүрэмд тусгуулмаар байна. Жижиг хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийн хувийг нэмүүлмээр байна. Том хувьцаа эзэмшигчдийн гаргасан шийдвэрт нөлөөлөх боломжгүй байгаад байна. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

Л.Нарантуяа: Сайн байна уу? Таны асуултанд би хариулая. Компанийн хувьцааны нэрлэсэн үнэ гэдэг нь тогтмол үнэ бөгөөд таний худалдаж авсан 150 төгрөг гэсэн үнэ нь тухайн компанийн үнэлгээнээс шалтгаалан гарч ирсэн зах зээлийн үнэ юм. Хоёр ялгаатай ойлголт учир таний авсан хувьцаа 50 төгрөг болоод уначихсан дүрэмд тусгагдаж байгаа гэсэн үг биш юм. Таний худалдан авсан хувьцааны үнэ нь зах зээл дээрх эрэлтээс шалтгаалан өсч, буурч өдөр болгон өөрчлөгдөж байгаа. Энэхүү байнга өөрчлөгдөж буй зах зээлийн үнийг дүрэмд тусгах боломжгүй юм. Хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшиж буй хувьцааны тоогоор саналаа өгөх эрх нь нээлттэй байгаа. Нэг хувьцаа нэг саналын эрхтэй байхаар Компанийн тухай хуулинд тусгагдсан байгаа учир тэрхүү хувийг өөрчлөх боломжгүй юм байна.

Хувьцаа эзэмшигч Даваасүрэн: Санал хураалт авч байгаа програм аудит хийгдсэн үү? Хурлын ирц 86,33%-д хүрч байгаа юу?

Л.Нарантуяа: Сайн байна уу? Санал хураалтыг авч байгаа програм нь Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагыг хангасан та бүгдийн саналыг өөрчлөх боломжгүйгээр хурлын бүх мэдээлэл Санхүүгийн зохицуулах хороонд хүргэгдэхээр програмчлагдсан. Хувьцаа эзэмшигчдийн ирцийн хувьд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоогоор бус хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны тоогоор тооцоологддог тул энэхүү хурлын ирц нь өндөр харагдаж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Цэцгээ: Сэндли ББСБ-ийн олгодог жижиг дунд бизнес эрхлэгч нарт олгодог зээлийг энэхүү хямралын үед ихээхэн хэрэглэж, үүний хүчинд би хямралд өртөөгүй, ар гэрээ тэжээж чадсан. Би энэхүү хуралд оролцож өөрийн та бүхэн баярласан, талархсан сэтгэлээ илэрхийлэхийг хүссэн юм.

Б.Наранбат: Таньд баярлалаа. Бидний үйл ажиллагааг дэмжиж, итгэж ашигладаг, хөрөнгө оруулан хувьцаа эзэмшигч болсонд тань бид бүхэн мөн адил баяртай байна. Ингээд санал хураалтын дүнг танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Д.Баярбатыг урьж байна.

Д.Баярбат: Санал хураалтын шугам хаагдсан байна. Үүгээр санал хураалт явагдаж дууссан тул санал хураалтын дүнг уншиж танилцуулая. Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь: “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч тус бүр дараах байдлаар кумулятив санал авсан байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

№	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Саналын тоо	Саналын хувь
Ердийн гишүүд			
1	Баттулга Наранбат	163,861,262	11,49%
2	Мөнхтөр Цолмон	161,584,581	11,34%
3	Найдан Билгүүн	153,973,345	10,80%
4	Лхагважав Нарантуяа	157,721,129	11,06%
5	Батбаяр Эрдэнэ	156,336,706	10,97%
6	Wonsuk Stephen Rhee	8,139,529	0,57%
7	Нармандах Цэвэгмид	156,753,904	11,00%
Хараат бус гишүүд			
1	Баатархүү Анужин	152,0595,546	10,67%
2	Цэндсүрэн Саруултуяа	155,198,047	10,89%
3	Батмөнх Цэлмэг	155,278,096	10,89%
4	Ганбаатар Анхбаяр	4,595,503	0,32%

“Сэндли ББСБ” ХК-ийн дүрэм (Шинэчилсэн найруулга) батлах тухай шийдвэрийн төслийг хуралд оролцсон саналын эрхийн 99,98 % зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

Б.Наранбат: Санал хураалтын дүнтэй танилцлаа. Энэхүү хурлаар үндсэн хоёр асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд гарах шийдвэрийн төслийг танилцуулья. Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол

***“Сэндли ББСБ” ХХК-ийг ХК болгон хэлбэрийг өөрчлөх,
“Сэндли ББСБ” хувьцаат компанийн дүрмийг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, 62.1.16 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүн, тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. Компани нийт энгийн хувьцааныхаа 29.97 хувийг Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй хүрээнд амжилттай арилжаалсантай холбогдуулан “Сэндли ББСБ” ХХК (хязгаарлагдмал хариуцлагатай компани)-ийг “Сэндли ББСБ” ХК (нээлттэй хувьцаат компани) болгон өөрчилсүгэй.

2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 3,350,000,000 (Гурван тэрбум гурван зуун тавин сая) төгрөгөөр нэмэгдүүлж, нэг бүр нь 50 (тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 223,570,000 (Хоёр зуун хорин гурван сая таван зуун далан мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 11,178,500,000 (арван нэгэн тэрбум нэг зуун далан найман сая таван зуун мянга) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг дурдсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны тоо, эзэмшлийн хувийг дор дурдсанаар баталгаажуулсугай.

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо ширхэг	Нэрлэсэн үнэ	Нийт дүн	Эзэмшлийн хувь
1	“Монголын финтек групп” ХК	126,141,700	50	6,307,085,000	56.42%
2	“Радикс технологи” ХХК	1,714,200	50	85,710,000	0.77%
3	Батдорж Нямжаргал	285,700	50	14,285,000	0.12%
4	Зургаа Цолмон	107,100	50	5,355,000	0.05%
5	Чойжоо Дашсүрэн	71,400	50	3,570,000	0.03%
6	Лхагважав Нарантуяа	71,400	50	3,570,000	0.03%
7	Охиндоо Нямдэлэг	71,400	50	3,570,000	0.03%
8	Ганхуяг Саруул-Од	71,400	50	3,570,000	0.03%
9	Гантөмөр Гантуяа	35,700	50	1,785,000	0.02%
10	“Сэндли эмплөйе” ХХК	20,000,000	50	1,000,000,000	8.95%
11	Б.Наранбат	8,000,000	50	400,000,000	3.57%
12	Олон нийт	67,000,000	50	3,350,000,000	29.97%
	Нийт	223,570,000	50	11,178,500,000	100%

4. “Сэндли ББСБ хувьцаат компанийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

5. Энэхүү тогтоолыг зохих журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, олон нийтэд мэдээлж, холбогдох баримт бичгийг хүргүүлэх, хувьцаат компанийн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Г.Гантуяа/ нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Наранбат/-д тус тус үүрэг болгосугай.

“Сэндли ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3, “Сэндли ББСБ” ХХК-ийн дүрмийн холбогдох заалт, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:

1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Баттулга овогтой Наранбат;
- 1.1.2. Мөнхтөр овогтой Цолмон;
- 1.1.3. Лхагважав овогтой Нарантуяа;
- 1.1.4. Найдан овогтой Билгүүн;
- 1.1.5. Нармандах овогтой Цэвэгмид;

- 1.1.6. Батбаяр овогтой Эрдэнэ.
- 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Баатархүү овогтой Анужин;
 - 1.2.2. Батмөнх овогтой Цэлмэг;
 - 1.2.3. Цэндсүрэн овогтой Саруултуяа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай. Компани нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөнтэй холбоотойгоор “Сэндли ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д хүргэхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Г.Гантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

Б.Наранбат: “Сэндли ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар үндсэн хоёр асуудлыг хэлэлцэн баталлаа. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвх санаачлагатай оролцож, өөрсдийн үнэт саналаа өгсөн та бүхэндээ баярлалаа. Компанийн цаашдын үйл ажиллагаанд та бүгдийн оролцоо юу юунаас илүү чухал гэдгийг энэ дашрамд хэлмээр байна аа. Ингээд “Сэндли ББСБ” ХК-ийн өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал өндөрлөснийг мэдэгдье.

Шийдвэрлэсэн асуудал:

1. Дүрэм батлах тухай
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Хурлын дуу, дүрст протоколыг хавсаргав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга


Б.Наранбат


Г.Гантуяа